



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

**Ажилтнуудын үндсэн цалингийн сүлжээг
шинэчлэн батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дэх заалт, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.6 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Бизнес төлөвлөгөө”, Цалин урамшууллын хорооны 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ажилтнуудын үндсэн цалингийн сүлжээг 2023 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээгээр нэмэгдүүлж ажилтнуудын үндсэн цалингийн сүлжээг шинэчлэн батлах талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хорооны дүгнэлтийг дэмжсүгэй.
2. Цалин урамшууллын хорооны дүгнэлтийг дэмжсэнтэй холбогдуулан компанийн нийт ажилтнуудын үндсэн цалингийн сүлжээг шинэчлэн батлахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Н.Улаанхүү/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1523010075